



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/98/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэчимэг Утас: 261628 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК Утас:99862066, 99041628 Цахим хаяг: peakomaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 29 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.БАТМЯГМАР ТАНАА

2023.02.24 № 07/390
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.4-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтад 275 суралцагч хамрагдаж, 140 багш ажиллаж байгаа бөгөөд удирдлага 3 удаа солигдсон байна.

Боловсрол шинжлэх ухааны яамнаас сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2024 оны 2-р сарын 12-ны өдөр хүртэлхи хугацаагаар олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар авсан арга хэмжээний хүрээнд шугамын алдагдлыг буруулснаар 6,317.7 мянган төгрөгийн цэвэр бохир усны зардлын хэмнэлтийг бий болгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>118,479,443.24</u>	<u>70,363,876.05</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	118,479,443.24	70,363,876.05
351	Түүхий эд материал	8,995,201.01	4,136,049.44
35130	Эм боох материал	8,995,201.01	4,136,049.44
354	Хангамжийн материал	109,484,242.23	66,227,826.61
35410	Бичиг хэргийн материал	443,850.00	257,300.00
35420	Аж ахуйн материал	2,288,693.77	229,421.00
35440	Түлш, шатах тослох материал	849,688.01	6,070.00
35450	Барилгын засварын материал	4,897,605.00	132,100.00
35460	Хүнсний материал	3,639,144.98	4,425,544.75
35470	Бусад хангамжийн материал	97,365,260.46	61,177,390.86
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,678,927,407.80</u>	<u>4,669,648,784.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,678,927,407.80	4,669,648,784.15
392	Биет хөрөнгө	4,133,463,087.80	4,124,184,464.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,082,676,048.00	4,082,676,048.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(379,185,060.12)	(482,266,880.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,974,891.00	126,974,891.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,074,828.27)	(58,364,845.55)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	649,525,144.22	661,174,608.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	(487,024,415.30)	(436,761,732.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	197,467,489.27	259,855,868.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(159,753,126.25)	(172,511,829.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	219,362,587.40	219,362,587.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(88,567,463.60)	(102,016,072.40)
39217	Ном	26,061,821.45	26,061,821.45
393	Биет бус хөрөнгө	545,464,320.00	545,464,320.00
39301	Программ хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,540,000.00)	(1,540,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	545,464,320.00	545,464,320.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,797,406,851.04</u>	<u>4,740,012,660.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,444,986.39</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,444,986.39	0.00
413	Өглөг	5,444,986.39	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,444,986.39	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,791,961,864.65</u>	<u>4,740,012,660.20</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,791,961,864.65	4,740,012,660.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,767,655,847.77	2,767,655,847.77
51101	Өмч: - төрийн	2,767,655,847.77	2,767,655,847.77
512	Хуримтлагдсан үр дүн	(1,013,258,559.46)	(1,065,207,763.91)
51210	Өмнөх үеийн үр дүн	(986,718,149.98)	(992,799,460.69)
51220	Тайлант үеийн үр дүн	(26,540,409.48)	(72,408,303.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,037,564,576.34	3,037,564,576.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,797,406,851.04</u>	<u>4,740,012,660.20</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,347,548,244.40	3,394,750,422.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	130,174,677.40	153,946,222.00
120	Нийтлэг татварын бус орлого	130,174,677.40	153,946,222.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	130,174,677.40	153,946,222.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	130,174,677.40	153,946,222.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,217,373,567.00	3,240,804,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,214,238,200.00	3,238,944,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,214,238,200.00	3,238,944,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,135,367.00	1,860,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	835,367.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,300,000.00	1,860,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,374,088,653.88	3,467,158,725.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,374,088,653.88	3,467,158,725.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,906,175,798.17	3,157,003,096.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,246,595,046.70	2,362,568,848.95
210101	Үндсэн цалин	1,749,095,549.70	1,433,965,764.17
210102	Нэмэгдэл	497,499,497.00	689,291,250.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	115,746,251.01
210104	Урамшуулал	-	123,565,583.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	243,186,807.95	281,558,155.88
210201	Тэтгэврийн даатгал	167,090,073.57	202,012,131.95
210202	Тэтгэмжийн даатгал	20,995,495.94	20,390,235.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,632,227.26	16,258,248.17
210204	Ажилгүйдлийн даатгал	3,482,324.06	3,899,547.62
210205	Эрүүл мэндийн даатгал	34,986,687.12	38,997,992.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,305,756.39	122,042,811.45
210301	Гэрэл, цахилгаан	17,797,870.80	32,453,591.13
210302	Түлш, халаалт	52,911,771.59	46,090,298.32
210303	Цэвэр, бохир ус	45,596,114.00	43,498,922.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,434,883.87	35,401,960.78
210401	Бичиг хэрэг	6,989,655.65	2,671,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,700,611.99	10,429,018.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,137,850.00	2,117,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,385,200.00	3,105,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,221,566.23	17,015,382.77
210408	Бараа материал акталсны зардал	-	63,400.00
2105	Нормативт зардал	31,663,235.09	70,217,864.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,227,474.14	12,528,191.57
210502	Хоол, хүнс	14,064,260.95	56,230,573.23

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,371,500.00	1,459,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,332,141.00	5,532,985.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	767,480.00
210604	Урсгал засвар	13,332,141.00	4,765,505.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,050,080.00	46,952,499.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,998,230.00	39,485,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,700.00	311,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	325,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	87,000.00	116,769.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,448,650.00	4,213,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,607,847.17	232,727,970.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,501,600.00	40,310,985.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,204,587.00	6,752,240.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	168,901,660.17	185,664,744.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,912,855.71	310,155,628.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,311,740.14	192,126,056.15
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,549,728.36	78,529,684.65
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	216,785,700.00	109,088,371.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,976,311.78	4,508,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	221,601,115.57	118,029,572.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	221,601,115.57	118,029,572.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(26,540,409.48)</u>	<u>(72,408,303.22)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(26,540,409.48)</u>	<u>(72,408,303.22)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(986,718,149.98)	4,818,502,274.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(986,718,149.98)	4,818,502,274.13
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(26,540,409.48)	(26,540,409.48)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(1,013,258,559.46)	4,791,961,864.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			20,459,098.77	20,459,098.77
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(992,799,460.69)	4,812,420,963.42
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			(72,408,303.22)	(72,408,303.22)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(1,065,207,763.91)	4,740,012,660.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,217,373,567.00</u>	<u>3,240,804,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,217,373,567.00	3,240,804,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,214,238,200.00	3,238,944,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,214,238,200.00	3,238,944,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,135,367.00	1,860,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	835,367.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,300,000.00	1,860,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,207,431,267.00</u>	<u>3,238,584,400.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,207,431,267.00	3,238,584,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,733,180,423.43	2,927,437,436.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,209,621,887.32	2,362,568,848.95
210101	Үндсэн цалин	1,261,005,630.32	1,433,965,764.17
210102	Нэмэгдэл	948,616,257.00	689,291,250.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	115,746,251.01
210104	Урамшуулал	-	123,565,583.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	280,255,079.11	281,558,155.88
210201	Тэтгэврийн даатгал	200,804,599.10	202,012,131.95
210202	Тэтгэмжийн даатгал	22,129,379.38	20,390,235.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,378,052.35	16,258,248.17
210204	Ажилгүйдлийн даатгал	3,616,327.78	3,899,547.62
210205	Эрүүл мэндийн даатгал	36,326,720.50	38,997,992.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,115,600.00	127,487,797.84
210301	Гэрэл, цахилгаан	17,797,870.80	32,453,591.13
210302	Түлш, халаалт	46,721,615.20	51,535,284.71
210303	Цэвэр, бохир ус	45,596,114.00	43,498,922.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,289,647.00	32,229,870.00
210401	Бичиг хэрэг	4,162,000.00	2,484,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,273,500.00	9,585,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,137,850.00	2,117,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,940,567.00	3,105,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,775,730.00	14,936,860.00
2105	Нормативт зардал	28,254,534.00	67,006,013.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,169,960.00	5,896,440.00
210502	Хоол, хүнс	16,925,174.00	56,773,473.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,159,400.00	4,336,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,360,186.00	27,500.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,380,700.00	27,500.00
210604	Урсгал засвар	12,979,486.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,566,150.00	36,399,799.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,514,300.00	28,933,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,700.00	311,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	325,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	87,000.00	116,769.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,448,650.00	4,213,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,717,340.00	20,159,451.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,423,600.00	12,167,851.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,293,740.00	7,991,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	474,250,843.57	311,146,963.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	252,649,728.00	193,117,391.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,982,828.00	79,521,020.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	216,785,700.00	109,088,371.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,881,200.00	4,508,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	221,601,115.57	118,029,572.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	221,601,115.57	118,029,572.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,942,300.00</u>	<u>2,219,800.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,942,300.00	2,219,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,942,300.00	2,219,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,942,300.00	2,219,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,942,300.00	2,219,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,942,300.00)</u>	<u>(2,219,800.00)</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,238,944,200.00	3,120,914,627.84	118,029,572.16	96.4
УРСГАЛ ЗАРДАЛ	3,238,944,200.00	3,120,914,627.84	118,029,572.16	96.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,043,683,500.00	2,928,397,236.34	115,286,263.66	96.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,371,929,000.00	2,362,568,848.95	9,360,151.05	99.6
Үндсэн цалин	1,219,538,500.00	1,433,965,764.17	(214,427,264.17)	117.6
Нэмэгдэл	887,490,700.00	689,291,250.77	198,199,449.23	77.7
Унаа хоолны хөнгөлөлт	80,850,000.00	115,746,251.01	(34,896,251.01)	143.2
Урамшуулал	184,049,800.00	123,565,583.00	60,484,217.00	67.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	292,139,600.00	281,558,155.88	10,581,444.12	96.4
Тэтгэврийн даатгал	209,348,600.00	202,012,131.95	7,336,468.05	96.5
Тэтгэмжийн даатгал	20,697,800.00	20,390,235.23	307,564.77	98.5
ҮОМШӨ-ний даатгал	16,558,200.00	16,258,248.17	299,951.83	98.2
Ажилгүйдлийн даатгал	4,139,500.00	3,899,547.62	239,952.38	94.2
Эрүүл мэндийн даатгал	41,395,500.00	38,997,992.91	2,397,507.09	94.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,506,200.00	126,227,797.84	40,278,402.16	75.8
Гэрэл, цахилгаан	31,311,500.00	32,453,591.13	(1,142,091.13)	103.7
Түлш, халаалт	86,636,100.00	51,535,284.71	35,100,815.29	59.5
Цэвэр, бохир ус	48,558,600.00	42,238,922.00	6,319,678.00	87.0
Хангамж, бараа материалын зардал	32,246,900.00	32,229,870.00	17,030.00	99.9
Бичиг хэрэг	1,659,200.00	2,484,550.00	(825,350.00)	149.7
Тээвэр, шатахуун	9,646,600.00	9,585,400.00	61,200.00	99.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,718,200.00	2,117,850.00	600,350.00	77.9
Ном, хэвлэл	2,376,000.00	-	2,376,000.00	-
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,450,100.00	3,105,210.00	344,890.00	90.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,396,800.00	14,936,860.00	(2,540,060.00)	120.5
Нормативт зардал	68,219,700.00	67,006,013.00	1,213,687.00	98.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,942,200.00	5,896,440.00	45,760.00	99.2
Хоол, хүнс	57,941,400.00	56,773,473.00	1,167,927.00	98.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,336,100.00	4,336,100.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	43,438,800.00	1,587,300.00	41,851,500.00	3.7
Багаж, техник, хэрэгсэл	43,438,800.00	1,587,300.00	41,851,500.00	3.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,317,700.00	36,399,799.67	6,917,900.33	84.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,027,600.00	28,933,230.00	1,094,370.00	96.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	311,400.00	311,400.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	330,800.00	325,400.00	5,400.00	98.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	330,800.00	116,769.67	214,030.33	35.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,817,100.00	4,213,000.00	5,604,100.00	42.9

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	25,885,600.00	20,819,451.00	5,066,149.00	80.4
Бараа үйлчилгээний бусад зардал	17,234,000.00	12,167,851.00	5,066,149.00	70.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,651,600.00	8,651,600.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,260,700.00	192,517,391.50	2,743,308.50	98.6
Бусад урсгал шилжүүлэг	195,260,700.00	192,517,391.50	2,743,308.50	98.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,246,200.00	79,521,020.00	2,725,180.00	96.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	109,106,500.00	109,088,371.50	18,128.50	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,908,000.00	3,908,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,238,944,200.00	3,120,914,627.84	118,029,572.16	96.4
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,238,944,200.00	3,120,914,627.84	118,029,572.16	96.4
Улсын төсвөөс	3,238,944,200.00	3,120,914,627.84	118,029,572.16	96.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	426	426	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	150	150	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	88	88	-	100.0
Үйлчлэх ажилтан	61	61	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	275	275	-	100.0
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	275	275	-	100.0
Төрийн өмчит ЕБС	275	275	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,860,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,860,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,260,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,260,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,260,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,860,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,860,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,860,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,787.2 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 19,452.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 19,197.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 254.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 19,452.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон 33,740.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ариутгалын материалын худалдан авалтыг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасан байна.	1	266.5			1	266.5	1	266.5				
Тайлант онд бусад үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг алдаатай тооцсон, мөн машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлын үлдэх өртгийг алдаатай илэрхийлсэн байна.	1	32,520.7			1	32,520.7	1	32,520.7				
Дүн	2	32,787.2			2	32,787.2	2	32,787.2				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2	Өмнөх оны аудитаар биетээр оршин байхгүй байсан 1,169.2 мянган төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютерыг өмнө ажиллаж байсан нягтлан бодогчоор төлүүлэхээр тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүгчийн захирамжаар 15,257.6 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосныг авлагаар тусгаж, холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх" гэсэн албан шаардлага хүргүүлснийг биелүүлж ажиллаагүй	1	16,426.8							1	16,426.8		
3	Соог зүйч багшийн ажилд түр томилогдсон ажилтанд захирлын тушаалд заасан хувь хэмжээнээс илүү тооцсон	1	527.7			1	527.7						
4	Бараа материалын тайланд хүнсний материалын тайланд тайлагнасан зарлагын дүн нь анхан шатны баримт, бүртгэлээс зөрүүтэй байна.	1	1,243.4			1	1,243.4						
5	Тайлант оны эхэнд "Бичиг хэрэг, архивын ажилтан" гэсэн 1 орон тоог баталсан боловч 12 дугаар сард тухайн ажилтанд үндсэн цалингийн 40 хувиар "Архив"-ын ажил хавсарсан гүйцэтгэсний цалин олгосон	1	254.4					1	254.4				
	Дүн	5	19,452.3			3	2,771.1	1	254.4	1	16,426.8		